

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА, ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК ХООРОНДЫН
ГУРВАН ТАЛТ ХЭЛЦЭЛ**

2018.10.29

Хэрлэн сум

Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймгийн Засаг дарга, Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд байгаль орчныг хамгаалах, ажиллагсадын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцөлийг сайжруулах, ажиллах хүч сонгох, хөдөлмөр зуучлал, газрын тос тээвэрлэлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, орон нутгийн аж ахуйн нэгжийг дэмжих, аймаг, сум, орон нутагтай хамтран ажиллах чиглэлээр харилцан зөвшилцөж энэхүү 3 талт хэлцлийг байгуулав.

1. Ажиллагсадын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийн талаар

- 1.1 Ажилтан ажиллагсдын амьдрах орчин нөхцлийг Монгол улсын холбогдох стандартад нийцүүлнэ.

2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- 2.1 Гэрээлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нутгийн захиргааны байгууллагын саналыг зөвшилцөн тусгах бөгөөд Ашигт малтмал газрын тосны газар нь орон нутгийн тусгасан саналыг хэрэгжүүлэх хөрөнгийг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгаж батална.
- 2.2 Гэрээлэгч компани тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг тухайн оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор батлуулна.
- 2.3 Бүтээгдэхүүн хуваах гэрээт 19 дүгээр талбайгаас Бичигт боомт чиглэлийн автозамын Дорнод аймгийн нутагт хамаарах хэсэгт тээвэрлэлтээс үүссэн газрын хөрсний эвдрэлийг нөхөн сэргээх ажилд шаардлагатай хөрөнгийг 2019 оны төлөвлөгөө, төсөвт батлуулж гүйцэтгэнэ.
- 2.4 Газрын тосны олборлолтод газрын доорхи хүн, малын ундны цэвэр ус ашиглахгүй бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ус хамгийн багаар хэрэглэдэг тэргүүний дэвшилтэт, технологи нэвтрүүлж ажиллана.
- 2.5 Нутгийн захиргааны байгууллагаас цахим сүлжээгээр бүтээгдэхүүн хуваах гэрээт 19, 21 дүгээр талбайн газрын доорхи усны түвшинг хянах нөхцлийг гэрээлэгчийн зүгээс бүрдүүлж ажиллана.
- 2.6 Бүтээгдэхүүн хуваах гэрээт 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн 58 км хатуу хучилттай автозам ашиглалтад орсноос хойш 1 жилийн хугацаанд газрын тосны тээвэрлэлтээс үүссэн олон салаа замыг бүрэн нөхөн сэргээсэн байна.

3. Газрын тосны тээвэрлэлт, хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр:

- 3.1 Бүтээгдэхүүн хуваах гэрээт 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн газрын тос тээвэрлэлтийн 58 км хатуу хучилттай автозамыг 2019 онд багтаан ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг гэрээлэгч компани бүрэн шийдвэрлэж, тус автозамыг Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Петрочайна Дачин Тамсаг ХХК гурван талын дэмжлэгтэйгээр барьж дуусгана.
- 3.2 Бүтээгдэхүүн хуваах гэрээт 19 дүгээр талбайгаас Бичигт хилийн боомт чиглэлийн автозамын газрын тосны тээвэрлэлтийн явцад засвар арчлалтыг тогтмол хийж, олон салаа зам гаргахгүйгээр хянаж ажиллана.
- 3.3 Гэрээлэгч нь бүтээгдэхүүн хуваах гэрээт 19, 21 дүгээр талбайд суурьшлын бүсийн төлөвлөлтийг 2019 онд багтаан батлуулан, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.
- 3.4 Бүтээгдэхүүн хуваах гэрээт 19, 21 дүгээр талбайгаас Чойбалсан хот хүртэлх автозам дагуу стандартын шаардлага хангасан тэмдэг, тэмдэглэгээ, мэдээлэх самбар байршуулах ажлыг 2019 онд багтаан гүйцэтгэнэ.

4. Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих:

- 4.1 Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх болон үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгохдоо ил тод, нээлттэй тендэр зохион байгуулна. Тендэрийн шаардлагад нийцсэн нийт аж ахуйн нэгжүүдээс орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт давуу эрх олгоно.

5. Ажиллах хүч сонгох чиглэлээр:

- 5.1 Ажиллах хүчийг Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагаар дамжуулан бүртгэлтэй ажил хайгч иргэдээс холбогдох хууль дүрэм, журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж авна.

6. Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:

- 6.1 Петрочайна дачин тамсаг ХХК нь Дорнод аймгийн төвд аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллах нэгжийг 2019 оны 3 дугаар сард багтаан байгуулна. Холбогдох мэдээллийг харилцан солилцож байна.
- 6.2 Гэрээлэгч нь хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлнэ.
- 6.3 Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн сумын орон нутгийн хөгжлийн санд, 20 хувийг Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх асуудлаар Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймаг санаачлагатай ажиллана.

- 6.4 Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар болон гэрээлэгч нар үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон нутгийн уулзалтыг жил бүрийн 2 болон 4 дүгээр улиралд буюу жилд 2 удаа Дорнод аймагт зохион байгуулна.
- 6.5 Нутгийн захиргааны байгууллага нь Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олборлолтын болон тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулахад хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
- 6.6 Хууль тогтоомжийн дагуу үндсэн ажилтан ажиллагсадын 75-аас доошгүй хувь нь Монгол ажилтан, ажиллагсад байна.
- 6.7 Ашигт малтмал, газрын тосны газар нь тус гэрээлэгчээс сургалтын урамшууллын санд төвлөрүүлсэн 75.000 /далан таван мянга/ америк долларын 50-аас доошгүй хувийг Дорнод аймгийн иргэдийг сургахад зарцуулна.
- 6.8 Аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Петровича дачин тамсаг ХХК-ийн ашиглалт, олборлолтын үйл ажиллагаатай холбогдох нээлттэй мэдээ, мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газраас Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газарт сар бүр ирүүлнэ.

7. Бусад

- 7.1 Энэхүү хэлцэл нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд мөрдөгдөнө.
- 7.2 Хэлцлийн хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол гурван тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.3 Хэлцлийн хэрэгжилтийг талууд жилд хоёр удаа дүгнэнэ.
- 7.4 Газрын тосны олборлолтонд нөлөөлөх арга хэмжээг авахаар бол 1 сарын өмнө талуудад албан ёсоор мэдэгдэнэ. Талууд газрын тосны олборлолтын хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 7.5 Хэлцлийг Монгол, Хятад хэл тус бүр дээр 3 хувь үйлдэх бөгөөд орчуулгатай холбоотой маргаан гарвал Монгол хэл дээрх хувийг баримтлан

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ДАРГА

Х.ХЭРЛЭН

ДОРНОД АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ПЕТРОВИЧА ДАЧИН ТАМСАГ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

ЕРӨНХИЙЛӨГЧ

ЖЯН ХУН ФУ

